



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/180

Ховд

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6, олон үндэстэн ястны өв соёл, урлаг хөтөлбөрийн 2.1 дэх заалтын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор угсаатны өв соёлыг сурталчлан таниулах тоглолтоо зохион байгуулж буй Ховд аймгийн харьяат Монгол Улсын гавьяат жүжигчин Д.Амаржаргал, Монгол Улсын гавьяат жүжигчин Ж.Мандухай нарын урлагийн тоглолтод 10,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт олгож буй 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2024 онд төлөвлөсөн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.БОЛОРМАА